

ДИЗАЙН ЗУРАГ ЗҮЙН ОНЛАЙН ОЛИМПИАДЫН Ш ШАТНЫ ДААЛГАВАР

Төрөл: Интерьер дизайн /Орчны дизайн/, /Баг/

Даалгавар: “Ширээний чийдэн”-ийн макет гүйцэтгэх.

Гүйцэтгэх ажил:

1. Олимпиадын II шатад дизайн шийдлыг боловсруулсан “Ширээний чийдэн”-ийн зураг төслийн дагуу макет гүйцэтгэх.

Макетийн гүйцэтгэлд:

1. Чийдэнгийн суурь хэсэг, тулгуур бүтэц, гэрлийн толгой зэрэг үндсэн хэсгүүдийн зохион байгуулалтыг тодорхой харуулах
2. Хэрэглэгчид тав тухтай ашиглах эргономик шийдэл тусгасан байх
3. Материалын сонголт болон түүний гоо зүйн шийдлийг илэрхийлэх

Анхаарах зүйлс:

- Макетийг олимпиадын II шатад гүйцэтгэсэн зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байна.
- Макет нь цэвэр, нямбай гүйцэтгэлтэй байх
- Ширээний чийдэнгийн бүтэц, хэсгүүдийг ойлгомжтой харуулсан

Үнэлгээ:

Үнэлгээний шалгуур	Хувь	Тайлбар
Зураг төслийн дагуу гүйцэтгэл	30%	Олимпиадын II шатанд боловсруулсан зураг төслийг макетад зөв, алдаагүй хэрэгжүүлсэн эсэхийг үнэлнэ. Хэлбэр, хэмжээ, пропорц, хийц нь анхны зурагтай нийцсэн, санаа алдагдаагүй байх шаардлагатай.
Бүтцийн шийдэл	30%	Чийдэнгийн суурь, тулгуур, гэрлийн толгой зэрэг үндсэн хэсгүүдийн зохион байгуулалт ойлгомжтой байх. Холболт, тогтвортой байдал, хөдөлгөөнт хэсгийн шийдэл бодитой эсэхийг үнэлнэ.
Техникийн бүрэн бүтэн байдал	40%	Макетийн гүйцэтгэл цэвэр, нямбай байх. Хэмжээс, пропорц зөв, хийц бат бөх, хэсгүүдийн холболт сайн, бүтцийн алдаа байхгүй байх.

Нөөц, материал:

- Шугам
- Харандаа
- Хайч
- Цаасны хутга
- Цавуу (цаасны болон түргэн хатдаг)
- Баллуур
- Гортиг
- Ватум цаас. А1 хэмжээгээр 2ш

Боловсруулсан: Багш доктор (Ph.D) Г.Эрдэнэтулга